



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 411

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай


Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтын 14.1.1, 14.1.2, 15 дугаар зүйлийн 15.12 дахь хэсгийн 15.12.2, 15.12.3, 15.12.11, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, мөн хуулийн 40, 41 дүгээр зүйл, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2014 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байгууллагыг нэгдүгээр, тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон байгууллагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я.Буянжаргал/-т үүрэг болгосугай.

САЙД

Н.УДВАЛ



D:\barimt\tushaal

082450

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
11 сарын 22 өдрийн 411 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

Нэг. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох байгууллага

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1.	Хос билэгийн далай ХХК	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх, худалдах	3 жил
2.	Энгүй гоо медикал ХХК	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх, худалдах	3 жил
3.	Лайфтроник ХХК	Багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, оношлуур импортлох, ханган нийлүүлэх, худалдах	3 жил
4.	Эделанд хараат ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн багаж тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
5.	Интимейт ХХК	Эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх, худалдах	3 жил
6.	Дархан намнан ХХК	Эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх, худалдах	3 жил
7.	ЭМЖЖЭМ ХХК	Харшлын вакцин, оношлуур импортлох, ханган нийлүүлэх, худалдах /Нэмэлтээр/	3 жил
8.	Нонаба ХХК	"Мөнхийн үйлс 2" эмнэлэг- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний, оношилгоо, эмчилгээний 40 ортой эмнэлэг	3 жил
9.	Хан шүтээн ХХК	Мэдрэлийн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө, гэмтэл, нөхөн сэргээх эмчилгээний чиглэлээр тусламж үзүүлэх 30 ортой эмнэлэг	3 жил
10.	Мобина ХХК	"Клевер медикал" нөхөн сэргээх, гоо сайхны мэс заслын эмнэлэг	3 жил
11.	Монголиан медикал сервис групп ХХК	Хан наж эмнэлэг- Яс, үений, гэмтэл, эмгэг, ясны хавдар, хөдөлгөөн хомсдолын сэргээн засах эмчилгээний 40 ортой эмнэлэг	3 жил
12.	Халдваргүйжүүлэлт ХХК	Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис импортлох, ханган нийлүүлэх, худалдах	3 жил
13.	Омбол ХХК	Ариутгал, халдваргүйтгэлийн бодис импортлох, ханган нийлүүлэх, худалдах	3 жил

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
11 сарын 28 өдрийн 411 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

Хоёр. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болгох байгууллага

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1.	Ионсей найрамдал	Хүүхэд, сэргээн засах өдрийн эмчилгээ